

ХӨГЖМИЙН БАГШ БЭЛТГЭХ АЖЛЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Н.Долгорсүрэн, магистр

МУБИС-ийн БС-ийн Бага боловсролын аргазүйн тэнхимийн багш

Abstract: One of the changes and reforms being implemented in education sector of Mongolia is the developmental issues of art, culture and music education. The study aims at conducting research on how music teachers of primary and secondary schools have been trained and at exploring the possibilities to establish a classic school to train music teachers at MNUE. We have raised the urgent issues and conducted survey to find any possibilities whether the credit hours of music course can be added to the primary school teacher preparation curriculum to improve the professional skills of music teachers to be taught at schools. The survey comprised totally 300 students from 6 schools of MNUE, and music teachers and primary school teachers from both cities and local provinces (Uvs, Sukhbaatar, Bayankhongor, Bulgan, Khentii). The result of the survey shows that music lessons are extremely important for student teachers.

Түлхүүр үг: МУБИС, Багшийн сургууль, дуу хөгжмийн багш, дуу хөгжмийн хичээл, судалгаа

Удиртгал

Монголын орчин цагийн хөгжмийн урлагийн хөгжилд МУБИС-ийн гүйцэтгэсэн үүрэг болон ЕБС-ийн хөгжмийн багш бэлтгэлийн уламжлал, шинэчлэлийн талаар тоймлон дүгнэж, цаашид МУБИС-д хөгжмийн багш бэлтгэх боломжийг энэхүү өгүүлэлдээ судалсан болно.

Энэхүү асуудлыг судлахдаа дараах

зорилтуудыг дэвшүүлэн тавилаа

- МУБИС нь монголын анхны дээд боловсролтой урлагийн мэргэжилтнүүдийг бэлтгэж байсан түүхэн хөгжлийг тоймлон судлах
- Монгол улсад бага, дунд боловсролын дуу хөгжмийн мэргэжлийн багш бэлтгэж ирсэн уламжлал, шинэчлэлийг харьцуулан судалж, цаашдын чиг хандлагаа тодорхойлох
- Зарим гадаад, дотоодын их, дээд сургуулийн хөгжмийн ангийн төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг судлах, харьцуулах

Хөгжим нь хүүхдийн өв тэгш хөгжилд нөлөөлж, тэдний ёс суртахуун-гоо сайхны сэтгэлхөдлөлийг өдөөх, хүрээлэн буй орчноо сайн сайхнаар хүлээн авдаг сэтгэлгээг төлөвшүүлэхэд чухал хэрэглүүр хэмээдэг. Гэтэл тэдэнд хөгжмийн боловсрол олгох учиртай багш, боловсон хүчний асуудал манайд тулгамдаж буйг “Соёл ба хөгжил” чуулганы хүрээнд зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр урлагийн гавьяат зүтгэлтэн Д.Жанчив онцолсон билээ.

“Сургуулийн өмнөх болон бага, дунд ангийн сурагчдыг гоо сайхны ертөнцөд татан оролцуулахад хамгийн оновчтой үе учраас тэдэнд хөгжмийн боловсрол олгох, хөгжимлөг сэтгэлгээ төлөвшүүлэх үүрэгтэй багш, сурган хүмүүжүүлэгчдийг бэлтгэх асуудлыг цогцоор нь шийдэх шаардлагатай байна.

Манайд хөгжмийн багш бэлтгэж эхэлснээс хойш хагас зуун жил өнгөрч, СУИС-ийн Соёлын боловсролын сургуулийнхан одоо ч энэ үүргээ гүйцэтгэсээр буй. Гэвч



энэ нь нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна. Эдүгээ олон сургууль, цэцэрлэг хөгжмийн багшгүй байдаг нь үүний нотолгоо” хэмээжээ.

Түүнчлэн хөгжмийн багш нарыг хүүхдэд зөвхөн дуу, шүлэг заадаг хүн төдийхнөөр ухаардаг ойлголт хэдийн хуучирсан. Өнөө цагт хүүхдийг хөгжмийн цагаан толгойн мэдэгдэхүүнтэй, урлагийн хөгжлийн түүх, түүний төрөл зүйлийн тухай наад захын ойлголттой болгох, хөгжмийн зэмсгээр тоглож сурах эрмэлзлийг төлөвшүүлэхийн тулд өөрөө өндөр чадвартай байх учиртай гэдгийг ч тэрбээр ярьсан байдаг.

Хөгжмийн талаар олон судлаач, хөгжмийн зохиолч, эрдэмтэд тал бүрээс нь оношилсон байдаг. Тухайлбал: Зөвлөлтийн хөгжим судлаач, академич Б.Асафьев “Хүн нийгмийн хөгжлийн үе шатуудад хүмүүсийн нээсэн шинжлэх ухааны бүтээл бус тэдний ололт, өөрсдөө нээж, хийсэн бүхэн гайхамшиг юм” хэмээн үзсэн бол Зөвлөлтийн нэрт сурган хүмүүжүүлэгч В.А.Сухомлинский “Хөгжмийн боловсрол гэдэг зөвхөн хөгжимчдийг бэлтгэн сургах бус, юуны өмнө хүнийг хүмүүжүүлэх явдал юм” хэмээн тодорхойлсон байдаг.

Калифорний Их сургуулийн доктор Гордон Шоо судалгаандаа сургалтын хөтөлбөртөө хөгжмийн хичээлийг оруулсан сургуулиудын суралцагчдын сурлагын амжилт харьцангуй сайн байгааг дурдсан байдаг.

Калифорны их сургуулийн 7500 гаруй оюутны дунд хийсэн судалгаанд хөгжмийн багшийн ангийн оюутнуудын унших, сэтгэн бодох чадварын үзүүлэлт нь англи хэл, биологи, хими, математик зэрэг бусад мэргэжлийн ангийн оюутнуудаас харьцангуй өндөр гарсан ажээ.

Нэг: МУБИС нь соёл урлагийн эх уурхай болох нь



МУБИС нь 1921 оноос нийгмийн эрэлт хэрэгцээний дагуу 60 гаруй мэргэжлээр дээд, тусгай дунд боловсролтой 60 гаруй мянган багш, соёлын ажилтан бэлтгэж ирсэн түүхэн уламжлалтай. Улмаар хөгжимчин, хөгжмийн зохиолч, удирдаач, жүжигчин, найруулагч, хөгжмийн багш, зохиолч, сэтгүүлч, орчуулагч, уран зураач, тамирчин, дасгалжуулагч зэрэг 10 гаруй мэргэжлээр дээд боловсролтой боловсон хүчин бэлтгэж, монголын соёл урлаг, биеийн тамирын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулжээ. Тэр хэмжээгээр ард түмэн, төр засгийнхаа хайр хүндэтгэлийг хүлээн институтээс их сургууль болтлоо хөгжиж ирсэн байна.

Монголын орчин цагийн хөгжмийн урлагийн хөгжилд Улсын Багшийн Дээд Сургууль /одоогийн Монгол Улсын Боловсролын Их Сургууль нь монголын анхны дээд боловсролтой урлагийн мэргэжилтэнүүдийг кино драм /1960/, үндэсний дуу бүжиг, хөгжмийн багш, удирдаачийн /1969/ жүжигчин, дуулаач зэргээр бэлтгэж төгсгөж 1983 онд биеийн тамир, урлагийн факультетийг байгуулан ажиллажээ. Тухайлбал,

Кино драмын тэнхим: СнЗ-ийн 1959 оны 331-р тогтоолоор УБДС-ийн дэргэд 1959- 1960 оны хичээлийн жилээс жүжигчний мэргэжлийг нээн хичээллүүлж, 1963-1964 оны хичээлийн жилээс соёл урлагийн тэнхим, 1979 оноос кино драмын тэнхим нэртэйгээр сургалтаа явуулж жүжигчин, найруулагчийн мэргэжлээр 245 хүн төгссөн бөгөөд 1969-1970- аад онд үндэсний хөгжмийн зохиолчийн мэргэжлээр 15, удирдаачаар 15 хүн төгсжээ.

Найрал дууны тэнхим: 1960 онд УБДС-ийн дэргэд дээд боловсролтой мэргэжлийн дуучин бэлтгэж эхэлснээр нийт 164 мэргэжлийн дуучин, 34 дуу хөгжмийн багшийг энэ тэнхим төгсгөжээ. Энэ үед зөвлөлтийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөө боловсруулж тэднийг дагалдан сурч сургалтаа явуулж ирсэн юм. Мэргэжлийн ганцаарчилсан сургалтыг Ардын жүжигчин Ц.Пүрэвдорж, Г.Хайдав, Д.Жаргалсайхан, А.Хавлааш, Х.Уртнасан, гавьяат жүжигчин Г.Цэвэлсүрэн, А.Загдсүрэн, Д.Жамьянжав, Д.Банди болон багш Д.Дашиймаа, О.Ичинхорлоо, Д.Дамдинсүрэн, Г.Гэлэгжамц нар зааж байв.

Соёл урлагийн факультет: ШУТДБУХ, БТСУХ-ны хамтарсан 14/63-р тогтоол, Сангийн яамны сайд, ШУТДБУХ-ны даргын 254/266 тоот тушаалыг үндэслэн ректорын 1989 оны 308 тоот тушаалаар БГУФ-ийг 1989 оны 9 дүгээр сарын 1-нээс татан буулгаж, соёл урлагийн факультет, биеийн тамирын факультет болгон өөрчилжээ. Соёл урлагийн факультетийн деканаар ардын жүжүгчин Г.Хайдав томилогдон ажилласан ба факультетийн харьяанд ардын хөгжим, соёл гэгээрлийн ажилтны мэргэжлийг шинээр нээжээ. БНМАУ-ын СнЗ-ийн 1990 оны 292-р тогтоолоор тус сургуулийн Соёл урлагийн факультетийн суурин дээр Соёл урлагийн дээд сургууль байгуулан улмаар Соёл урлагийн их сургууль болтлоо хөгжиж байна.

МУБИС-ийн Багшийн сургуулийн хувьд бага ангийн багш бэлтгэхээс гадна 13 төрөл мэргэжлээр боловсон хүчин бэлтгэж ирсэн

байна. Багшийн сургууль нь хөгжмийн багшийг 53 жил, Соёлын ажилтаныг 50 жил бэлтгэж, бага ангийн багшийн ангид 93 жил тасралтгүй бүх нийтийн урлаг, уран сайхны соёлыг төлөвшүүлэхэд шаардлагатай мэргэжлийн багш, боловсон хүчнийг бэлтгэж ирсэн түүхэн уламжлалтай болно.

Улмаар 1924 онд багш бэлтгэх сургуулийн 1-р курст “Дууны хичээл” 1-р курсд /Лянхуа багш/ анх эхлэн орсноос хойш эдүгээ хүртэл хөтөлбөрүүд шинэчлэгдэн тасралтгүй 93 жил энэхүү хичээлийг зааж байна.

Дуу хөгжмийн багш бэлтгэсэн нь /1962-1998/

1961-1962 оны хичээлийн жилээс эхлэн Улаанбаатар хотын Багшийн Сургуулийн дэргэд Ерөнхий боловсролын дунд сургуулийн дуу хөгжмийн сургалтыг мэргэжлийн багшлах боловсон хүчнээр хангах үүд хаалгаа нэгдсэн ажээ. Дуу хөгжмийн багшийн ангид хөгжмийн онол, түүх, заах арга, гармони, соноршуулга, үндэсний хөгжим, баян хуур болон төгөлдөр хуур, мандолин, үлээвэр хөгжмийн хичээлээс гадна нийгмийн ухаан, ерөнхий эрдмийн хичээлүүд ордог байсан нь өнөөдрийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн суурь болж өгсөн байдаг.

Монгол улсад дуу хөгжмийн багш бэлтгэж эхэлснээс хойш эдүгээ 53 жил болсон бөгөөд энэхүү өндөрлөг дээрээс эргэн харахад: /багшийн сургуульд 36 жил/ тус сургуулиас Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин, Урлаг судлалын ухааны доктор Н.Жанцанноров, Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн Б.Шарав, Төрийн шагналт Ц.Нацагдорж, Х.Билэгжаргал, Ц.Чинзориг, Урлагийн гавьяат зүтгэлтэн З.Батсүх, Ч.Сангидорж, Ё.Цэрэндолгор, Б.Бямбабаяр, Т.Сэр-Од зэрэг авьяас билэгт уран бүтээлчид, Монгол Улсын Гавьяат жүжигчин, дуучин Ч.Туул, Х.Болормаа, уртын дуучин Д.Ширмэнтуяа, Монгол Улсын Гавьяат багш Ж.Найдан, Г.Бадам, Х.Баасанцэрэн зэрэг алдартнууд төрөн гарчээ. Дуу хөгжмийн багш бэлтгэгдсэн 36 жилийн хугацаанд багшийн сургуулийг **905** хөгжмийн багш төгссөн байдаг. /1998 онд



соёлын коллежид шилжсэнээс өмнөх/ 1999 оноос бакалаврын зэрэгтэй төгсгөж эхэлжээ. Бидний судалгаанд одоо ажиллаж байгаа /1983 оноос хойш/ 497 дипломын хөгжмийн багшийн 50% орчим нь мэргэжлээ дээшлүүлсэн гэж үзвэл 248 багш бакалавраар мэргэших хэрэгцээ байна.

Дуу хөгжмийн багш бэлтгэсэн 36 жилийн хугацаанд багшийн сургуулийн харьяанд байсан үеийн тоо баримтыг хүснэгтээр үзүүлвэл:

Хүснэгт 1

Он	1965	1966	1967	1968	1969	1970	1971	1972	1973	1974	1975
Төгсөлт	14	16	19	24	23	24	29	22	24	24	24
Он	1976	1977	1978	1979	1980	1981	1982	1983	1984	1985	1986
Төгсөлт	26	28	28	30	30	36	28	23	25	27	23
Он	1987	1988	1989	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997
Төгсөлт	22	36	42	43	40	30	62	19	14	13	37
Бүгд 905											

Цаашид бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн урлагийн боловсрол хичээлүүдэд суурилан, ерөнхий боловсролын бага, дунд сургуульд багшлах мэргэжлийн үйл ажиллагааны ерөнхий арга барил төлөвших үндсийг тавьж, сургуульд суралцахуйг зохион байгуулах дидактикийг гүнзгийрүүлэн судлах, багшлах дадлага хийх суурь мэдлэг, чадвартай болгоход “Дуу хөгжим-дидактик”-ийн хичээл чухал ач холбогдолтойгоос гадна МУБИС-д хөгжмийн багшаа бэлтгэх нь бидний эрхэм зорилт болоод байна.

Хөгжмийн анги: СнЗ 1965 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 158 тогтоолоор Багшийн сургуулийн дэргэд “Соёлын анги”-ийг нээжээ.

Соёлын ажилтан бэлтгэх зорилго нь төв, орон нутгийн соёлын байгууллагуудыг мэргэжилтэй боловсон хүчнээр хангахад оршиж байлаа. Гол хичээл нь соёл гэгээрлийн байгууллагуудаас зохиох ажлын агуулга арга зүй, үндэсний болон төгөлдөр баян хуурын ганцаарчилсан хичээлийн сургалтаар хөгжмийн онол, утга зохиол, түүх, найрал дуу, найрал хөгжим, найруулгын онол, практикийн олон хичээл ордог байв. Соёлын салбар 1965 оноос 1983 он хүртэл багшийн сургуулийн бүрэлдэхүүнд байж байгаад, хөгжим, соёл номын сангийн салбарууд 1983-1984 оны хичээлийн жилд соёлын дунд сургуулийг үүсэх үндсэн ангиуд болжээ.

Хүснэгт 2

1965 оноос өнөөг хүртэл бэлтгэгдсэн соёлын ажилтны тоо

Он	1969	1970	1971	1972	1973	1974	1975	1976	1977	1978	1979
Соёлын ажилтан	24	40	45	39	25	28	23	26	46	27	49
Он	1980	1981	1982	1983	Бүгд 525						
Соёлын ажилтан	40	32	49	32							

1950-аад оны үеэс цэцэрлэгүүдэд ажиллах дуу хөгжмийн багшийн орон тооны асуудлыг, тухайн цэцэрлэгийн хүмүүжүүлэгчид, хөгжмийн багш нар бүлгүүдийн хүүхдийн тооноос хамаарч бий болгож байсан байна.

1987 оноос УБДС-д цэцэрлэгийн дуу хөгжмийн багшийн мэргэжлээр элсэлт авч төгсгөсөн ба 1990 - 1996 онд хөгжмийн багшийн сургуультай нэгдэж, нийт 119 хөгжмийг

багшийг бэлтгэсэн байна.

Хоёр: Судалгаа, үр дүн /Хөгжмийн сургалтын хөгжил, улс орны харьцуулалт/

Хүснэгт 3

Хөгжмийн сургалтын төлөвлөгөөний хөгжил

Он	Нэр	Анги	7 хоногийн цаг
1926-1932	Дуу дуулах	1-4-р анги	1 цаг
1933-1939	Дуу хөгжим	5-7-р анги	2 цаг
1955-1962	Дуу	1-4-р анги	1 цаг
1963-1993	Дуу хөгжим	1-7-р ангид	1 цаг
1994-1997	Дуу хөгжим	1-5 анги	2 цаг
1998-2004	Дуу хөгжим	1-5-р анги	2 цаг
2005 -2006 11 жилийн шилжилт	Хөгжим бүжиг	1-9-р анги	1 цагаар
2006-2008	Хөгжим	1-9-р анги	1 цаг
2008-2009 12 жилийн шилжилт эдүгээ хүртэл	Хөгжим	1-4-р анги 5-9-р анги	2 цагаар 1 цагаар

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт дуу хөгжмийн хичээл нь 1926 оноос хойш 7 удаа шинэчлэгдэн судлагдаж байна.

Хүснэгт 4

Сургалтын төлөвлөгөөнд хөгжмийн хичээлийн цаг

Бүтэц	3+5+2	3+5+2	4+4+2	5+4+2	6+3+3	5+4+3
он	1972	1987	1998	2006	2007	2011
Цаг	449	447	609	550	580	429
Эзлэх хувь	5,6%	5,7%	9,5%	6,6%	7,9%	4,0%

3.Зарим улс орнуудын сургалтын төлөвлөгөөний цагийн харьцуулалт

Хүснэгт 5

Гоо зүй- хөгжмийн хичээлийн харьцуулалт

Улс орнууд	Гоо зүй хөгжим	Бага боловсрол		Суурь боловсрол		Бүрэн дунд боловсрол		Нийт цаг
		цаг	хувь	цаг	хувь	цаг	хувь	
Солонгос	Гоо зүй	1064	20,8	442	15,5	204	9,6	1710
Япон	Гоо зүй	552	11,7	220	9,9	140	9,8	912
Орос	Гоо зүй	280	9,5	280	5,4			560
Герман	Гоо зүй	532	14,0	432	8,8	335	13,6	1299
Монгол	Хөгжим	550			6,6	-	-	550

Эх сурвалж: Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Алтанцэцэгийн 11 жилийн сургалтын төлөвлөгөө боловсруулахтай холбоотой хийсэн харьцуулсан судалгаанаас авав.

4.Бага боловсролын багш бэлтгэх сургалтын төлөвлөгөөний олон улсын харьцуулалт



Хүснэгт 6

Б. Бага ангийн багш бэлтгэдэг их дээд сургуулийн цагийн харьцуулалт

Монгол	кр	Америк	кр	Япон	кр	ОХУ	цаг
Мэргэшүүлэх хичээл	82	Мэргэшүүлэх хичээл	34	Мэргэшүүлэх хичээл	73	Мэргэшүүлэх хичээл	
Дуу хөгжим дидактик	3	Дуу хөгжим	3	Дуу хөгжим	8	Хөгжим хүмүүжлийн онол арга зүй	250ц

Энэхүү судалгаанаас харахад Япон улс багшаар бэлтгэж байгаа ангидаа хөгжмийн хичээлийн 8 кредит судалдаг нь дээрх 3 орноосоо харьцангуй их байгаа нь үндэсний соёл урлаг, хөгжмийн хичээлээр хүнээ хөгжүүлэхэд илүүтэй анхаардагтай холбоотой гэж үзэж байна.


Урьдчилсан судалгаа хийгдэж судлагдсан байдал

Бид сүүлийн 3 жилд МУБИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын хөтөлбөрт хөгжмийн хичээл 1-2 улирал судлах боломж, бага ангийн багш- хөгжмийн хичээлээ заах, хөрвөх чадвартай багшийг бэлтгэх, бакалаврын хөгжмийн багш бэлтгэх зэрэг нийгмийн тулгамдсан асуудлаар нилээдгүй судалж, асуудал дэвшүүлж ажиллалаа.

1. МУБИС-ийн бүрэлдэхүүн ДУТС, Гадаад хэл, Боловсрол судлал, ТНУС, Багшийн сургууль, Монгол судлал/өөрчлөлтийн өмнөх нэрээр/ зэрэг 6 сургуулийн 300 гаруй оюутнаас “Багш бэлтгэх сургуульдаа хөгжмийн хичээл судлах нь зөв үү” гэсэн асуулга судалгаанд 94% нь зөв гэж хариулсан байдаг. Энэ нь хүүхдэд хөгжлийн хичээл чухал хэрэгтэй байгааг харуулж байна гэж дүгнэж үзлээ.

2. Багшийн сургуулийн модул сургалтад хамрагдсан болон Увс, Сүхбаатар аймгийн 283 бага ангийн багш/ оролцсон судалгааны дүнг диаграммаар толилуулж байна.

Асуулга 1. Та хөгжмийн хичээл заах, хөрвөх сургалттай анги нээгдвэл сурах уу?



Судалгаанд хамрагдагсadyг бүсчилж, зэрэг цолоор ангилан харуулбал:

	Зүүн бүс	Баруун бүс	Говийн бүс	Төвийн бүс	бүгд
Дипломын	37	27	11	23	98
Бакалавр	52	74	21	36	183
Магистр		1		1	2
Зөвлөх		1			1
Тэргүүлэх	5	7	3	4	19
Заах аргач	12	9	5	11	37


Судалгаанд оролцогчдын 226 буюу 79,8% нь сурна гэж хариулжээ. Энэ нь цаг үеийн эрэлт хэрэгцээ болон багш нар өөр мэргэжлээр хөрвөн сурах сонирхолтой байгааг харуулж байна.

1. **Хөгжмийн багш болох авьяас, сонирхолтой юу?** гэсэн асуулгад судалгаанд багшийн сургуулийн хөгжмийн сонгоны ангийн 36, УБТС-ийн 14, Боловсрол судлалын сургуулийн

8, СӨБС-ийн 25, НХУС-ийн 13 оюутан судалгаанд хамрагдсан бөгөөд 300 оюутны 96 оюутан буюу 32% нь авьяас сонирхолтой, тэд МУБИС-д хөгжмийн багш бэлтгэвэл суралцах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн нь энэ мэргэжлээр суралцах сонирхолтой оюутнууд цөөнгүй байгаа гэдгийг илэрхийлэл болж байна.

2. Сүхбаатар аймагт “Боловсролын чанарын шинэчлэл” сургалтад хамрагдсан 100 хүн /БСГ-ын мэргэжилтэн, сургуулийн захирал, сургалтын менежер, төрөл мэргэжлийн багш/-ээс авсан санал болон асуулга судалгааг дүгнэж үзэхэд:

Та аймаг, сумуудын ЕБС-ийн хөгжмийн багш нарын заах арга, мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон судалгааг нэгтгэн үзүүлбэл:



Оролцогчид	Сайн	Дунд зэрэг	Хангалтгүй
БСГ мэргэжилтэн	1	1	
Захирал	1	13	1
Сургалтын менежер		28	6
Багш нар	7	33	9
Бүгд	9	85	16

Сүхбаатар аймгийн ЕБС-ийн хөгжмийн багш нарын 85% -ийг нь дундаж, 16% -ийг нь хангалтгүй түвшинд байгаа гэж удирдлага хамт олон нь үнэлж байгаа нь хөгжмийн багш нарыг мэргэшүүлэх шаардлагатай хэмээн үзэж болохоор байна.

Мөн бага ангийн багшийг мэргэшүүлэх талаарх саналыг нэгтгэвэл:


- БАБ нарыг сургалтандаа хөгжим хэрэглэдэг чадвартай болгох
- БАБ нарыг хөгжмийн багшаар мэргэшүүлэх
- Багшийн сургуульд хөгжмийн хичээлийг 4 жил сонгон судлах

Хөгжмийн багш нарын ур чадварын талаарх саналыг дурдвал:

- Хөгжмийн багш нарыг мэргэшүүлэх, сургалтад өргөн хамруулах шаардлагатай
- Дипломын боловсролтой багшийг баклавар болгох
- Шинээр гарч буй хөгжмийн програмуудыг сургах




3. Хөгжмийн багш нар: Сүхбаатар аймгийн төвийн болон сургалтад ирсэн нийт 14 багш:



Судалгаанд хамрагдсан 14 багшийн 13 нь дипломын, 12 нь зэрэггүй байгаа нь дээрх судалгааны дүгнэлттэй нийцэж байна. Иймээс 15 –аас дээш жил ажилласан хөгжмийн багш нараа МУБИС-ийн Багшийн сургуульд бакалаврын 1 жилийн хөгжмийн анги нээж мэргэшүүлэх боломж байна.

4. Хөдөөгийн орон нутгаас: Увс 29, Баянхонгор

14, Булган 6, Хэнтий 8, Сүхбаатар 14, Өмнөговь 9, нийт 80 хөгжмийн багш нараас түүвэрлэн авсан судалгаа.



Дээрх судалгаанаас харахад хөдөө орон нутагт төдийлөн сургалтад хамрагдах боломжгүй, ялангуяа хөтөлбөр боловсруулах, бичиг баримт хөтлөх, судалгаа хийх, багш мэргэжлийн арга зүйн сургалтууд эрэлт хэрэгцээтэй байгааг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Өнөөдрийн хөгжмийн багш нарыг бэлтгэж байгаа байдал, тэндээс гарсан боловсон хүчний чанар, авьяас чадвар нь өмнөх үеэсээ эрс буурч хөгжмийн сайн зохиолчид ховордож, хөгжмийн багш нарын боловсрол судлал, эрх зүй, сэтгэл судлал, судалгаа арга зүйн мэдлэг чадвар дутмаг өөрийгөө дайчлан хөгжүүлэх, бие дааж суралцах мэргэжил боловсролоо дээшлүүлэх, төсөл хөтөлбөрт хамрагдан ажиллах, ном сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл бичих, судалгаа хийх, магистр, доктор хамгаалах зэрэг орчин үеийн шаардлагаас хоцрогдож байгаа нь бидний судалгаанаас харагдаж байна.

Монголын боловсролын салбар дах төрөл мэргэжлийн багш нарыг бэлтгэдэг үндэсний их сургуулийн хувьд манай МУБИС нь:

- Ерөнхий боловсролын сургуулиудад эрэлт хэрэгцээ болсон хөгжмийн багш нарыг Урлаг, биеийн тамирын сургуульдаа бэлтгэх
- Багшийн сургуульд судалж байгаа цагийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах.
- **“Хөгжмийн багшийн 1 жилийн бакалаврын анги”** нээсэн тохиолдолд хөгжмийн 240 гаруй, бага боловсролын 196 багш, нийт 436 хөгжмийн болон бага ангийн багш мэргэшлээ дээшлүүлнэ гэсэн судалгааны үр дүнд дүгнэлт хийж, хамтран ажиллах боломжтой байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Батсүх, Ч. (2012). *Хүүхдийн хөгжим гоо зүйн боловсролд хийх сургалтын технологийн шинэчлэл*. Монгол: Мөнхийн үсэг.
- Дон, Кампбелл. (2011). *Хүүхдэд хөгжим сонсгожхөгжүүлэнхүмүүжүүлэх нь*. Монгол: Монсудар.
- Жамбалдорж, Т. Монгол Улсын Боловсролын Их сургууль 1951-2006. Улаанбаатар
- Пүрэвсүрэн, Д. (2007). *Монголын хөгжмийн боловсролын уламжлал, шинэчлэл*. Монгол: Сод пресс.
- Монгол Улсын Боловсролын Их Сургууль.

(2008). Багшийн сургуулийн сургалтын төлөвлөгөө. Монгол: Содпресс.

Монгол Улсын Боловсролын Их Сургууль. БСС.БС.СӨБС. (2012). *Оюуны хөтөч сэтгүүл*. Улаанбаатар

Содномваанчиг, Г. (2009). Монголын бага, дунд боловсролын сургалтын агуулгын хөгжлийн түүхэн тойм. Улаанбаатар Битпресс

Япон улсын Тамагава, Гакүгей их дээд сургууль, ОХУ-ын Улан-Үдийн Багшийн дээд сургуулийн сургалтын хөтөлбөрүүд 2012-1015. musicandteacher.blog.gogo.mn

Professor Yuri Nikolayevich Holopov (musicologist), Moscow Conservatory, Russia
[<yuriikholopov@mail.ru>](mailto:yuriikholopov@mail.ru)

Dr. Ted Levin (Ethnomusicologist), Dartmouth College of Music, Ted.levin@dartmouth.edu